

**ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2006 ОНЫ ЭХНИЙ УЛИРЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

2006 оны эхний улиралд байгуулагдаад 1 жил гаруй болж байсан Их Эвслийн Засгийн газрын зарим гишүүд огцрох өргөдлөө гаргасныг УИХ-аар хэлэлцэн Засгийн газрыг огцруулж, үүний дараа Үндэсний Эв нэгдлийн Засгийн газар байгуулагдан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг баталсан. Тэргүүлэх чиглэлд дэвшүүлсэн зорилтуудыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг зохион байгуулж байна. 2006 оны эхний улиралд Засгийн газраас авч хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрээд байгаа арга хэмжээнүүдийн талаар товч дүгнэвэл:

- Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 5000 төгрөгөөр буюу **32.0** хувиар нэмэгдүүлж, 1998 оны 7 дугаар сарын 1-нээс өмнөх тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын хэмжээг 120.000 төгрөгөөр хязгаарлаж байсныг хүчингүй болгон, төрийн албан хаагчийн болон төсөвт байгууллагад ажиллагсдын цалингийн хэмжээг **30** хувиар нэмэгдүүлж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг **53000** төгрөг буюу нэг цагт **313** төгрөг **61** мөнгө байхаар тогтоосон нь нийгмийн салбарт хийгдсэн томоохон ажил боллоо.
- Шинээр гэр бүл болж буй залууст санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хүүхдийн мөнгийг гэр бүлийн орлого харгалзалгүй нийт хүүхдэд олгох, шинээр төрсөн хүүхдэд нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох, 55–аас дээш настай, алдарт эхийн одонтой эхчүүдэд жилд 1 удаа мөнгөн тусламж үзүүлэх, Улсын болон хөдөлмөрийн баатар, ардын цолтон, дайнд оролцсон ахмад дайчдад улирал тутам олгодог мөнгөн тусламжийг нэмэгдүүлж 50000 төгрөгт хүргэх, гавьяат цолтой ахмадуудад жилд 1 удаа олгодог мөнгөн тусламжийн хэмжээг нэмэгдүүлж 100.0 мянган төгрөгт хүргэхээр нэмж шаардагдах хөрөнгийг төсвийн тодотголын төсөлд тусгаад байна.
- Монгол Улсын Засгийн газар Дэлхийн банктай хамтран техникийн уулзалтыг зохион байгуулсан нь хөгжлийн хамтын ажиллагааны шинэ чиг хандлагыг Монгол Улсад нэвтрүүлэх, улмаар зээл, тусламжийн бодлогыг үндэсний хөгжлийн стратеги, улсын төсөв болон хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдуулах чухал алхам боллоо.
- Эмнэлгийн мэргэжилтнүүдэд олгодог байсан 157 төрлийн лицензийг цөөрүүлэн 4 болгож түүнийг сард 1 удаа хуралддаг комиссын шийдвэрийг үндэслэн олгодог байсныг материал болон кредит нь бүрдсэн тохиолдолд шууд олгож байхаар болов.
- Зам тээврийн салбарт 2006 онд 22.511 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөн зам, гүүрийн барилга байгууламж, төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байна.
- Манай улсын ихэнх нутагт цаг агаарын нөхцөл харьцангуй таатай байсан учраас мал өвөлжилтөд онцын хүндрэл гарсангүй, малын зүй бус хорогдол I улирлын байдлаар өнгөрсөн оны мөн үеийнхээс олон дахин бага байна.
- УИХ-ын дарга БНСУ, Швед, Норвеги, Финлянд, Данийн Вант Улс, Бүгд Найрамдах Финланд Улс, Норвегийн Вант Улсад айлчилж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх асуудлаар тодорхой тохиролцоонуудад хүрсэн. Монгол Улсын Ерөнхий сайд Япон Улсад хийсэн айлчлалын үеэр 2 шаттай иөнийн зээлийн хэлэлцээр байгуулсан нь Япон Улстай иж бүрэн тншлэлийн харилцааг баяжуулж, харилцан ашигтай байх чиглэлд хийсэн чухал алхам болов.
- Косово дахь НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд, “Афганистаны үндэсний армийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд, Сиерра Леон Улсад зохион байгуулж байгаа НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд манай улсын баг үүргээ амжилттай гүйцэтгэж байна.
- Монгол-Хятадын улсын хилийг хоёр дахь удаагаа хамтран шалгасан тухай Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Протокол болон түүний хавсралтуудыг УИХ-аар соёрхон батлууллаа.

1. НИЙГМИЙН БОДЛОГО

Боловсрол. Бага, суурь, бүрэн дунд боловсролын төгсөлтийн шалгалтын журмыг батлан хэрэгжүүлж байна. Энэ тушаалаар суралцагчид монгол хэл, математик, байгалийн ухаан, нийгмийн ухаан, гадаад хэл, технологийн чиглэлээр шалгалт өгөх бөгөөд шалгалтыг чиглэл тус бүрээр, эсвэл нэгдсэн байдлаар авч болохоор зохицууллаа.

▶ Энэ нь үнэлгээн дэх төвлөрлийг сааруулж, суралцагчдын сурлагын амжилтыг явцаар нь үнэлэх хандлагыг төлөвшүүлэхэд чиглэснээс гадна сургуулиуд бие даан төгсөлтийн шалгалтыг зохион байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн ажил боллоо.

“Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн эх загварт дүгнэлт гаргах шинжээчдийн ажиллах журам”-ыг батлан гаргалаа.

▶ Журмын дагуу 2006 онд хэвлэхээр зарласан 30 нэрийн сурах бичгийн 127 эх загварт шинжилгээ хийж, 72-ыг шалгаруулсан нь дунджаар нэг сурах бичигт 1-3 эх загвар шалгарсан байна.

▶ 2005 онд 17 нэрийн сурах бичиг шинээр хэвлэгдсэн бөгөөд 2006-2007 оны хичээлийн жил гэхэд ерөнхий боловсролын сургуулийн нийт сурах бичгийн 50 хувь нь шинэчлэгдэх юм.

ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газар, “Охано” сангаас ирүүлсэн 500 ширхэг англи хэлний электрон сурах бичиг, DVD тоглуулагчийг нийслэл, орон нутгийн сургуулиудад хуваарилан өгсөн нь англи хэлний сургалтын орчинг сайжруулахад дэмжлэг үзүүлээ.

БСШУ-ы сайд Австри Улсад айлчлал хийх үеэр Австрийн БСШУ-ы сайд нар хоёр орны боловсролын баримт бичиг харилцан хүлээн зөвшөөрөх тухай гэрээг үзэглэлээ.

▶ Ингэснээр манай улсын дээд боловсролын диплом тус улсад хүлээн зөвшөөрөгдөх юм.

Дээд боловсролын сургалтын байгууллага болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд 2006-2007 оны хичээлийн жилд суралцагч элсүүлэх, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын тусгай зөвшөөрөл, улсын бүртгэлийг шинэчлэх, гадаадад суралцагчдын сонгон шалгаруулах чиглэлээр дараах ажлыг гүйцэтгэлээ. Үүнд:

▶ Оюутан элсүүлэх ерөнхий шалгалтыг 1 удаа авахаар шийдвэрлэж, шалгалтыг улсын хэмжээнд 2006 оны 5 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд явуулахаар тогтоов.

▶ 2006-2007 оны хичээлийн жилд ОХУ-д 125, Украин Улсад 9, Казакстан Улсад 4, БНТУ-д 40, БНХАУ-д 50 оюутан, үүнээс бакалаварт 23, мэргэжил дээшлүүлэхэд 27 хүн тус тус суралцана. Оюутан, залуучууд гадаад оронд боловсрол эзэмших хүсэл эрс нэмэгдэж байгаа бөгөөд сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулалтын хувьд боловсронгуй болгох арга хэмжээ авах шаардлагатай нь ажиглагдлаа.

Соёл, урлагийн талаар: “Соёлын тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулаад байна.

▶ Төсөлд дэлхийн өвд бүртгэгдсэн байгалийн болон соёлын өвийг хамгаалахад зориулж төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх, гадаад улсын иргэн, байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэр дээр кино зураг авах асуудлыг тусгай журмаар зохицуулах, соёлын ажилтны ёс зүйн дүрэм батлах, хууль зөрчигчдөд хүлээлгэх захиргааны хариуцлагын шийтгэлийн төрлүүдийг нэмж тусгах зэрэг нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж байгаа.

Тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойн хүрээнд Австри Улсад Монголын соёлын өдрүүдийг зохион байгууллаа.

► Энэ үеэр Морин хуур чуулгын тоглолт, “Чингис хаан ба түүний өв залгамжлагчид”, Урчуудын эвлэлийн хорооны уран бүтээлчдийн “Монголын өнгө” уран зургийн үзэсгэлэнг зохион байгуулсан нь соёл, урлагийн гадаадад сурталчилгааны томоохон ажил боллоо.

Боловсрол, соёлын газрын болон Засаг даргын Тамгын газрын соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн, арга зүйчдийн сургалт-семинарыг зохион байгуулж, сумдын номын сангийн эрхлэгчдийн сургалтыг Соёлын дээд сургууль дээр зохион байгуулж эхлээд байна.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов.

Нийгмийн хамгаалал. Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 5000 төгрөгөөр буюу 32.0 хувиар нэмэгдүүлж, 20480 төгрөгт хүргэхээр болов.

► Нийгмийн халамжийн тэтгэврийн нэмэгдэлд 44.7 мянган хүн хамрагдаж 2.4 тэрбум төгрөг зарцуулна. 1998 оны 7 дугаар сарын 1-нээс өмнөх тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын хэмжээг 120.000 төгрөгөөр хязгаарлаж байсныг хүчингүй болгон, төсвөөс жилд 1.9 тэрбум төгрөг нэмж зарцуулахаар болов.

Төрийн албан хаагчийн болон төсөвт байгууллагад ажиллагсдын цалингийн хэмжээг эдийн засгийн өсөлт, инфляцын түвшинтэй уялдуулан 30 хувиар нэмэгдүүллээ.

► Ингэснээр 2006 оны жилийн эхний суурь цалинтай харьцуулахад улсын төсвөөс нийт 46.8 тэрбум төгрөг зарцуулж, төсөвт байгууллагын цалингийн сан 190.0 тэрбум төгрөгт хүрнэ.

► Цалин нэмэх арга хэмжээнд төрийн болон төсөвт байгууллагын нийт 124.6 мянган ажиллагсад хамрагдаж байгаа бөгөөд төрийн албан хаагчдын дундаж цалин 105 мянга төгрөгт хүрч байна.

“Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, “Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, “Зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” УИХ-ын тогтоолын төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр болов.

“Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын тогтоол гарган, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг сард **53000** төгрөг буюу нэг цагт **313** төгрөг **61** мөнгө байхаар тогтоолоо.

Шинээр гэр бүл болж буй залууст санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хүүхдийн мөнгийг гэр бүлийн орлого харгалзалгүй нийт хүүхдэд олгох, шинээр төрсөн хүүхдэд 1 удаагийн мөнгөн тэтгэмж олгох, 55–аас дээш настай, алдарт эхийн одонтой эхчүүдэд жилд 1 удаа мөнгөн тусламж үзүүлэх, Улсын болон хөдөлмөрийн баатар, ардын цолтон, дайнд оролцсон ахмад дайчдад улирал тутам олгодог мөнгөн тусламжийг нэмэгдүүлж 50000 төгрөгт хүргэх, гавьяат цолтой ахмадуудад жилд 1 удаа олгодог мөнгөн тусламжийн хэмжээг нэмэгдүүлж 100.0 мянган төгрөгт хүргэхээр нэмж шаардагдах хөрөнгийг төсвийн тодотголын төсөлд тусгаад байна.

Хүн амын хөгжил. “Хүн худалдах, хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах” асуудлаарх хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

► Хэлэлцүүлэг нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар төрийн болон ТББ-аас хэрхэн хамтарч ажиллах, төр засгаас баримтлах бодлогын чиглэлийг тогтооход чухал ач холбогдолтой боллоо.

Хөдөлмөр эрхлэлт. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлуулав.

▶ Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох замаар хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний нэр төрлийг олшруулах, албан бус хөдөлмөр эрхлэгчид, малчдыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулах, хөдөлмөр эрхлэлтийн шинэ үйлчилгээ, арга хэмжээг нэвтрүүлэх чиглэлээр хуульд нэмэлт, өөрчлөлт орууллаа.

▶ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг өргөжүүлснээр уг арга хэмжээнд жилд 21290 иргэн, үүнээс 3.5 мянган малчин, 3.0 мянган албан бус хөдөлмөр эрхлэгч, 9.0 мянган эмзэг бүлгийн иргэд нэмж хамрагдах боломжтой болох юм.

“Албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай” УИХ-ын тогтоолыг батлуулав.

▶ Бодлого батлагдсанаар албан бус хөдөлмөр эрхлэгчдийг төрийн үйлчилгээгээр дамжуулан албажих боломжийг бүрдүүлэх, эрсдлээс хамгаалах эрх зүй, эдийн засаг, хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгааг бий болгон улс орны эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг тоо, чанарын хувьд сайжруулан хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх боломж бүрдэх юм.

БНСУ-ын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн агентлагийн буцалтгүй тусламжаар ирүүлсэн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтын зориулалт бүхий 2000 ам.долларын ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэлийг хүлээн авлаа. Улсын мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн нөхцөлийн төв болон хөдөлмөрийн эрүүл ахуйн байцаагчдад шаардлагатай 37 мянган ам.долларын багаж, хэрэглэлийг гардуулав.

▶ Эдгээр тусламжийн бараа Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт, сурталчилгааны төв болон УМХГ-ын Хөдөлмөрийн нөхцөлийн төвийн материаллаг баазыг бэхжүүлэхэд ач холбогдолтой боллоо.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж: 2006 оны 2 дугаар сард нийгмийн даатгалын тэтгэвэрт 24.7 тэрбум төгрөг олгохоос 24.7 тэрбум төгрөгийн тэтгэврийг бүрэн олголоо. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогод 17.9 тэрбум төгрөг оруулахаас 19.4 тэрбум төгрөг оруулж, төлөвлөгөөг 108.3 хувиар биелүүлжээ.

Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж: 2 дугаар сард өссөн дүнгээр нийгмийн халамжийн тэтгэврийг 44744 хүнд олгож 1611.0 сая төгрөг, нийгмийн халамжийн тэтгэмжийг 687152 хүнд 5681.1 сая төгрөг олгов. Нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээнд 5303 хүнд 89.9 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн нийгмийн халамжийн үйлчилгээнд 4587 хүнд 170.8 сая төгрөг, ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт үйлчилгээнд 26207 хүнд 363.0 сая төгрөг зарцуулжээ.

Эрүүл мэнд. Урьд нь эмнэлгийн мэргэжилтнүүдэд олгодог байсан 157 төрлийн лицензийг цөөрүүлэн 4 болгож түүнийг сард 1 удаа хуралддаг комиссын шийдвэрийг үндэслэн олгодог байсныг болиулж, материал болон кредит нь бүрдсэн тохиолдолд шууд олгож байхаар боллоо.

ЭМЯ-ны “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл”-ийн комисс, “Магадлан итгэмжлэлийн зөвлөл”-ийн бүрэлдэхүүнд өмнө нь ороогүй байсан Хувийн хэвшлийн эрүүл мэндийн холбооны төлөөллийг оролцуулах шийдвэр гаргалаа.

Ахуйн шавьж, мэрэгчийн устгал, халдваргүйтгэлийн үйлчилгээ; Биологийн идэвхт үйлчилгээтэй бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх болон Эмчилгээний гоо заслын үйлчилгээ зэрэг хүний эрүүл мэндэд шууд нөлөөлж байдаг үйлчилгээг мэргэжлийн бус хүмүүс дураар явуулж байсныг ЭМЯ-ны тусгай зөвшөөрөлтэйгээр явуулахаар болов.

Сум, өрхийн эмнэлгийг харьяа хүн амын тоонд нь уялдуулан нэг хүнд ногдох тарифаар улсын төсвөөс санхүүжүүлэх өөрчлөлтийг Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд тусгаад байна.

Хөдөө, орон нутгийн эмнэлгүүдийг эмчээр хангах асуудлыг судалж санхүүгийн болон эрх зүйн хөшүүргүүдийг хэрэглэхээр Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт орууллаа.

▶ Анагаах ухааны сургууль төгссөн эмч нар сум, сум дунд, өрхийн эмнэлэгт 2 жилийн хугацаагаар заавал ажиллах боллоо.

▶ Сум, тосгон, сум дундын эмнэлэгт 3-аас дээш жил тогтвортой, үр бүтээлтэй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтнийг төрийн зардлаар төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад хамруулах, их эмчид 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг ажиллаж байгаа эрүүл мэндийн байгууллагаас олгохоор хуульд өөрчлөлт оруулаад байна.

▶ Эрүүл мэндийн байгууллагад 25 ба түүнээс дээш жил ажилласан эмнэлгийн мэргэжилтэнд тэтгэвэрт гарахад нь 12 сарын, үүнээс сум, тосгон, сум дундын эмнэлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан эмнэлгийн мэргэжилтэнд 18 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг зөвхөн эмч, сувилагчид олгож байсныг сумын эмнэлгийн жолооч, асрагч зэрэг бусад ажилтнуудад мөн хамруулахаар хуульд өөрчлөлт хийсэн.

Сувилахуйн удирдлагын бүтэц, зохион байгуулалт, ЭМЯ-ны сувилагчийн зөвлөлийн бүрэлдэхүүн, аймаг, нийслэлийн сувилагчийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлан мөрдүүлэв.

Баянхонгор аймгийн Жаргалант, Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Говь-Алтай аймгийн Бигэр сум, суурингийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зорилгоор дээрх сумын эмнэлгийг сум дундын эмнэлэг болгов.



Сум багийн түвшинд эрүүл мэндийн анхны тусламжийн үйлчилгээг тогтвортой, хүртээмжтэй хүргэх, сумын эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг зохицуулах үүднээс “Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам”-ыг батлан гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Нүүдлийн шувууд ирэх улирлыг угтуулан хүний томуугийн вакцинаар аймаг, нийслэлийн хүнс, хөдөө аж ахуй, хил, гааль, мэргэжлийн хяналт, онцгой байдлын газар, эрүүл мэндийн байгууллагын ажилтан, мэргэжилтэн, байцаагч зэрэг өртөмтгий бүлгийн хүн амыг тархвар судлалын заалтаар дархлаажуулах хуваарь гаргаж, хуваарийн дагуу дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг болон шинжилгээ, оношлогоог дараалал харгалзахгүй хийлгэж байхыг бүх шатны эмнэлгүүдийн дарга, захирал нарт үүрэг болгов.

2006 оны 2 дугаар сарын 28-ны байдлаар Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн хангамж нэр төрлөөр Улаанбаатар хотод 72%, хөдөө орон нутагт 55-65%-тай байна.

Жил бүрийн эхний улирлын байдлаар:



Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 8.2 мянга болсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 19.1 хувиар нэмэгдсэн байна.

2. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлуулав.

► Хуулиар Нягтлан бодох мэргэжлийн зөвлөлийг татан буулгаж, түүний гүйцэтгэж байсан чиг үүргийг Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлого, аргазүйн хэлтэс, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтэд хариуцуулж, аудитын компани, аудитор нарын эрх үүргийг улам тодорхой болгож, хариуцлагын тогтолцоог нэмэгдүүллээ.

Монгол Улсын Засгийн газар - гадаад түншүүдийн хамтарсан техникийн уулзалтыг Дэлхийн банкт хамтран зохион байгууллаа.

► Уулзалт нь хөгжлийн хамтын ажиллагааны шинэ чиг хандлагыг Монгол Улсад нэвтрүүлэх, улмаар зээл, тусламжийн бодлогыг үндэсний хөгжлийн стратеги, улсын төсөв болон хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдуулах анхны чухал алхам боллоо.

► Техникийн уулзалтаар гадаад түншүүдтэй хамтран зээл, тусламжийн шинэ арга хэрэгслийг тохиролцсон явдал чухал ололт боллоо. Энэхүү шинэ арга хэрэгсэл нь эдийн засгийн бодит хөгжлийг дэмжсэн, үр дүнд суурилсан, давхардлыг арилгасан, эргэж тайлагнадаг, ил тод байх зарчимд тулгуурлахад оршино.

Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Сэргээн босголтын зээлийн банк хооронд байгуулсан “Орон нутгийн зам сайжруулах” төслийн зээлийн гэрээг соёрхон батлах тухай, Монгол Улсын Засгийн газар, Шведийн Олон улсын хамтын ажиллагааны агентлагийн хооронд байгуулсан “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээг шинэчлэн засварлах” төслийн зээлийн гэрээг соёрхон батлах тухай хуулийг батлуулав.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Худалдан авах ажиллагаанд баримтлах тусгай журам болон Цахим сүлжээнд тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журмыг баталж мөрдүүллээ.

Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ, тарифын өөрчлөлттэй уялдуулан төрийн албан хаагчийн албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн тогтоолоо.

► Аймагт 15500 төгрөгөөр, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 23500 төгрөгөөр, төрийн тусгай болон төрийн үйлчилгээний албан хаагчийн

хувьд зам хоногийн зардлыг аймаг, нийслэлд 6500 төгрөгөөр, аймгийн төвөөс сумдад ажиллах төрийн албан хаагчийн албан томилолтын зам хоногийг зардлыг 4500 төгрөгөөр тогтоолоо.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол гарган, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудыг Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл, салбар тус бүрийн шинээр боловсруулах үндсэн чиглэл, төсөл, хөтөлбөрүүдэд тусгаж, харилцан уялдуулах арга хэмжээ авахаар заав.

Монгол Улсын 2006 оны төсвийн тодотголыг УИХ-аар хэлэлцүүлээ.

► Улсын төсвийн тодотголын төслөөр төсвийн орлого 943.9 тэрбум төгрөгт хүрч батлагдсанаас 92.7 тэрбум төгрөгөөр, төсвийн нийт зарлага 1 028.2 тэрбум төгрөгт хүрч батлагдсанаас 93.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэхээр тооцоо гарсан.

► Төрийн албан хаагчдын цалинг 30 хувиар нэмэгдүүлсэнтэй холбогдуулан цалингийн сангийн хэмжээг 22.1 тэрбум төгрөгөөр, бараа, үйлчилгээний зардлыг 24.7 тэрбум төгрөгөөр, татаас ба урсгал шилжүүлгийн зардлыг 27 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэв.

► Монгол-Оросын хамтарсан Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн Удирдах зөвлөлийн хурлаар тус үйлдвэрийн 2004 оны хуваарилагдаагүй ашгаас Монголын талд хуваарилж буй ногдол ашгийг 37.3 тэрбум төгрөг байхаар шийдвэрлэсэн тул түүнийг улсын төсөвт төвлөрүүлэхээр тусгажээ.


Бооцоот ба тааварт тоглоомын үйл ажиллагаа эрхэлдэг татвар төлөгчдөд онцгой албан татвар ногдуулах үүднээс Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтлоо.

► Бооцоот ба тааварт тоглоомын үйл ажиллагаанд оролцдог тоглоомын ширээ, тоглоомын үр дүнг харуулсан касс, букмекерийн контор зэргийн нэгж тутамд сард ногдуулах онцгой албан татварын хэмжээг 8000 ам.доллар, автомат тоглоомд сард ногдуулах онцгой албан татварын хэмжээг 3000 ам.доллар байхаар хуулийн төсөлд тусгасан болно.

Улсын төсвийн хөрөнгөөр 2006 онд гүйцэтгэх их засварын ажлын жагсаалтыг баталлгаа.

► Жагсаалтаар **6,098.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 220 орчим нэгж (объект)-ийн их засварын ажлын санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэв.**

Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага, тэнцэл, /эхний улирлын байдлаар/



- ⇒ Засгийн газар оны эхний улиралд гадаад зээлийн үндсэн төлбөрт 5.4 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 3.1 тэрбум төгрөг, нийт **8.5** тэрбум төгрөг төлжээ.
- ⇒ Засгийн газрын бондын үндсэн төлбөрт 3.9 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 243,6 сая төгрөг, бүгд **4.14** тэрбум төгрөг төлжээ.
- ⇒ Арилжааны банкуудаас дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу 2006 оны эхний улиралд зээлийн үндсэн төлбөрт 1.7 тэрбум төгрөг, зээлийн хүүгийн төлбөрт 2.4 тэрбум төгрөг, бүгд **4.1** тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэв.
- ⇒ Төрийн сангийн төгрөгийн болон гадаад валютын чөлөөт эх үүсвэрээс зарим арилжааны банкуудад шөнийн (овернайт) зээл олгож, валютын ба төгрөгийн богино хугацаат мөнгөн хадгаламжийг байршуулснаар 2006 оны эхний 3 сард нийтдээ **496.8** сая төгрөгийн хүүгийн орлогыг төрийн санд төвлөрүүлсэн.
- ⇒ Хадгаламжийн банкны дүрмийн санг нэмэгдүүлэхтэй уялдуулан 3.5 тэрбум төгрөгийн бондын арилжааг зохион байгуулж, төлбөр тооцоог гүйцэтгэсэн байна.

Үйлдвэрлэл. Оёмол, сүлжмэл эдлэлийн үйлдвэрийн нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг улсын төсвийн хуваарилагдаагүй зардлаас нөхөн олгох журмыг батлан, мөрдүүлэв.

▶ *Журмаар ажил олгогчоос төлсөн нийгмийн даатгалын төлбөрийн нөхөн олговрын хэмжээг 3-5 жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан бол 40 хувь, 5-аас дээш жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан бол 50 хувь байхаар тогтоолоо.*

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн бариад байна.

▶ *Хуулийн төсөлд ашигт малтмалын асуудлаар нийгэмд үүсэн бий болоод байгаа уур амьсгал, иргэний хөдөлгөөнүүдээс дэвшүүлж буй санал, шаардлага, хөрөнгө оруулагчдын санал, гадаад улсын туршлага, олон улсын байгууллагуудын гаргасан зөвлөмж зэргийг нарийвчлан судалж, дүн шинжилгээ хийж, иргэний хөдөлгөөн, хөрөнгө оруулагчид, тус салбарын эрдэмтэд, судлаачдыг оролцуулсан хэд хэдэн уулзалт ярилцлага зохион байгуулж, тэдний саналыг харгалзан салбарын хөгжлийн эрх ашиг, тус салбараас улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах хувь оролцоог нэмэгдүүлэх асуудлын тэнцвэрийг хангахад анхаарсан болно.*

“Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хууль батлагдан, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна.

Энэ хүрээнд газрын тосны бүтээгдэхүүнийг бөөнөөр импортлох, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох журам боловсруулж, батлаад байна.

Бүсийн зөвлөлийн дарга нартай Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих технологи хөгжлийн санг орон нутагт хэрэгжүүлэх хамтын ажиллагааны гэрээг байгуулан ажиллаж байна.

Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийн үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр БНХАУ-ын Шаньси мужийн Таюань хотын Уул уурхайн компанитай хамтран ажиллах талаар протокол байгуулав. ӨМӨЗО-ны Худалдааны танхимын удирдлагуудтай байнгын зөвлөлдөх ажлын хэсгийн протоколыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, ажлын дэд хэсгүүд байгуулах талаар харилцан санал солилцож, хоёр талд худалдаа, хөрөнгө оруулалтын төв байгуулах ажлыг эхлүүлэх чиглэлийг тогтов.

Монгол Улс-АНУ-ын стратегийн нийтлэг ашиг сонирхолд тулгуурласан “Иж бүрэн түншлэл ба Чөлөөт худалдаа хэлэлцээр” хэлэлцүүлэг зохион байгууллаа.

ОХУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Алтан Дорнод Монгол” ХХК-ийн алтны шороон орд руу өнгөрсөн оны 7 сард гар аргаар алт олборлогчид дайрч орон тус компанийн олборлохоор бэлтгэсэн шороон ордыг ашигласны улмаас ихээхэн хэмжээний хохирол учруулсан гэж үзэж манай улсын Засгийн газраас нэхэмжилсэн 3,7 тэрбэм төгрөгийн асуудлаар ярилцаж хүчингүй болгохоор шийдвэрлэв.

Монгол-АНУ-ын Худалдаа, хөрөнгө оруулалтын хамтарсан зөвлөлийн II хуралдаан болж, АНУ-ын Төрийн департамент, Худалдааны яам, Худалдаа хөгжлийн агентлаг, Экспорт-Импортын банк, Дэлхийн банк зэрэг байгууллагын удирдах албаны хүмүүстэй хоёр талын уулзалтууд хийж, худалдаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх асуудлаар санал солилцов. Монгол-Америкийн дугуй ширээний уулзалт зохион байгуулж, худалдаа, хөрөнгө оруулалт, уул уурхайн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх асуудлаар ярилцав.

Канадын Торонто хотноо зохион байгуулагдсан уул уурхайн салбарын олон улсын чуулга уулзалтад ҮХ-ны сайд Б.Жаргалсайхан манай улсын эдийн засгийн хөгжилд уул уурхайн салбарын гүйцэтгэж буй үүрэг, ач холбогдол, гадаадын хөрөнгө оруулалтын орчин, хамтын ажиллагааны байдал, цаашдын чиг хандлагын талаар үг хэлж, оролцогчдын асуултад хариулав.

Монгол Улс, БНУУ-ын Засгийн газар хоорондын “Эдийн засгийн хамтын ажиллагаа”-ны хэлэлцээрийг баталж, “БНМАУ-ын Цагаандавааны гянт болдын орд газрыг эзэмшихэд хамтран ажиллах тухай” 1984 орны хэлэлцээрийг цуцаллаа.

Гадаад улсад суугаа ДТГ-ын худалдаа, эдийн засгийн асуудал хариуцсан ажилтнуудын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулав.

ҮХЯ, Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсийн төлөөлөгчид Далянь хотод очиж хөрөнгө оруулагчаар шалгарсан Вест Прадайт компанийн удирдлагатай хэлэлцээ хийж, Чөлөөт бүс байгуулах ажлыг эхлүүлэх, хөрөнгө оруулалтыг түргэтгэх асуудлаар тохиролцоонд хүрлээ.

Тогтвортой байдлын гэрээ байгуулах яриа, хэлэлцээ явуулах ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, Татварын багц хууль, Ашигт малтмалын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлттэй нийцүүлэх, гэрээ байгуулах газруудад ажиллах монгол ажилчид, тэдний цалингийн доод хэмжээ, мэргэжлийн сургалт, эрчим хүчний хангамж, бүтээгдэхүүн гүнзгийрүүлэн боловсруулах үйлдвэр байгуулах зэрэг асуудлаар харилцан ашигтай гэрээ байгуулах, улмаар компанийн хувьцааг монголчууд эзэмших боломж олгох үүднээс энгийн хувьцааг Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэн худалдах ажлыг шийдвэрлэх талаар анхаарч ажиллаж байна.

3. БАЙГАЛЬ ОРЧИН

“Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүллээ.

“Хус бэлтгэхийг зогсоох тухай”, “Ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг тогтоох тухай” тушаалуудыг гарган мөрдүүлж байна.

Богдхан уулын дархан цаазат газар, Хустайн байгалийн цогцолборт газар, Батхаан уулын нөөц газар, тэдгээрийн хоорондын салбар уулсын халиун бугын тархац нөөцийн хээрийн судалгааг ШУА-ийн Биологийн хүрээлэнтэй хамтран зохион байгуулав.

2006 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг хэрэглээний мод 29.0 мянган шоо.метр түлээний мод, 570.0 мянган шоо.метрээр тогтоолоо.

“Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах” уулзалт ярилцлагад оролцон гэр хорооллын төлөвлөлтийн бодлогыг шинэчлэх замаар нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах талаар санал солилцлоо.

► “Хямд өртөгтэй шөнийн цахилгаан болон сэргээгдэх эрчим хүч, газрын гүний дулаан, шингэрүүлсэн шатдаг хий, шахмал түлшний хэрэглээг бий болгосноор Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах арга зам” сэдэвт уулзалт ярилцлагад оролцон сонгогдсон аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллахаар болов.

2006 онд улсын төвлөрсөн хөрөнгөөр аймаг, нийслэлийн захиалгаар хэрэгжүүлэх ойг тарьж ургуулах ажил, “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн хүрээнд үндсэн болон туслах зурвас байгуулах ажлыг баталгаажуулан хэрэгжүүлж байна.

НҮБ-ын Хүрээлэн буй орчны Хөтөлбөрийн Ази номхон далайн бүсийн захирал тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчилж, Монгол Улсын Байгаль орчны яам болон НҮБ-ын Хүрээлэн буй орчны Хөтөлбөрийн хооронд 2003 онд байгуулсан байгаль орчны чиглэлээр хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг дүгнэв.

► Байгаль орчны хууль эрх зүйн орчныг чиглэлээр ажлын хэсэг байгуулж судалгаа хийн, цаашид хамтарч ажиллах санамж бичгийг байгууллаа.

Биоаюулгүй байдлын тухай Картагений протоколын талуудын бага хурлын III уулзалт, Биологийн төрөл зүйлийг хамгаалах тухай конвенцийн талуудын VIII бага хуралд оролцлоо.

► Хурлаар хуурай газрын биологийн төрөл зүйл, уулын биологийн төрөл зүйл, гадны биологийн төрөл зүйл, генийн нөөцийн тогтвортой ашиглалт, биотехнологийг хэрэглэх, түүнээс гарах үр ашиг орлогын тэгш хуваарилалт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, таксономийн асуудлууд, ургамалын хамгаалалт, тогтвортой ашиглалт, уламжлалт арга ухаан, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх, биологийн төрөл зүйлийн хамгаалалт, зүй зохистой ашиглалтанд шаардагдах санхүүжилт зэрэг асуудлуудаас гадна Даян дэлхийн байгаль хамгаалах сантай хамтын ажиллагааны талаар харилцан санал солилцлоо.

Дэлхийн усны IV чуулганд болж, Даян дэлхийд тулгарч буй усны асуудлыг шийдвэрлэхэд улс орнуудын хийж гүйцэтгэж буй ажлын үр дүнг хэлэлцэж, тодорхой чиглэлүүдийг гаргав.

► Чуулганы үеэр Монгол Улсын хувьд анхаарлын төвд байдаг усны үр дүнтэй менежментийг бий болгох, бодлого төлөвлөлтөнд олон нийтийн оролцоог хэрхэн хангах цаашлаад улс орнууд усны чиглэлийн сүүлийн үеийн шилдэг арга технологийг хэрхэн солилцох талаар санал солилцов.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхээр хүсэлт гарган ирүүлсэн 34 төслийн материалаас Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэхээр 14 дүгнэлт гарган хүргүүлээ.

4. ХОТ БАЙГУУЛАЛТ, БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН БОДЛОГО

“Хот байгуулалтын тухай”, “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, 2006 онд “Хот, суурины газар нутгийн үүргийн бүсчлэлийн хил, нэр томъёоны стандарт”, “Хот, суурины газар нутгийн үүргийн бүсчлэлийн хязгаарт баригдахад зөвшөөрөгдөх барилга байгууламжийн нэр томъёоны стандарт”-уудыг боловсруулж байна.

“Хот суурины гудамж, зам төлөвлөлт” БНБД-32-04-04–ийг боловсруулаад байна.

► Тухайн нормоор иргэдийн эрүүл аж төрөхөд чухал шаардлагатай явган хүний гүйлтийн болон унадаг дугуйн зам, нээлттэй орон зай, талбай, ногоон байгууламжийг хот төлөвлөлтийн зайлшгүй элемент болгож, уг талбайд шаардагдах газрыг өөр зориулалтаар ашиглуулахаар олгохыг хязгаарлаж, хот суурин газрын авто зам, гудамж, талбайн тохижилтод иргэдийн аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдэх юм.

“Улаанбаатар хотын мастер төлөвлөгөөг шинэчлэх, Улаанбаатар болон бусад томоохон хотуудын орон зайн мэдээллийн санг бүрдүүлэх”, “Монгол орны малчин өрх бүрийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрээр хангах” зэрэг төслүүдийг хэрэгжүүлэх талаар Япон Улсын Засгийн газар, Дэд бүтцийн яамтай хамтран ажиллахаар тохиролцов.

“40000 орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд баригдах шинэ хотхон, хорооллуудын газрын асуудлыг шийдвэрлүүлэх ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Мөн энэ ажлын хүрээнд “Богд хан” уулын тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсэд өөрчлөлт оруулах чиглэлээр ажиллаж байна.

2005 оноос өмнө нийслэлээс гадна 4 аймаг энэ төлөвлөгөөг батлуулан мөрдөж байсан бол 2006 онд Баянхонгороос бусад бүх аймаг төлөвлөгөөтэй болсон байна.

► Энэ төлөвлөгөөний хүрээнд аймгийн нийт газар нутгийн нөхцөл, нөөцийн мэдээлэл, газар ашиглалтын тоон мэдээлэл бий болсноор орон нутагт газрын мэдээллийн сангийн суурь тавигдлаа.

Залуу гэр бүл, бага, дунд орлоготой өрхөд зориулсан нэг маягийн орон сууцны барилгын загвар төсөл сонгон шалгаруулах уралдааныг зохион байгуулав. Орон сууц хөгжүүлэх сангаас төрийн албан хаагчдад зээл олгох шалгуур үзүүлэлтийг батлуулав.

Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн 200 айлд дулааны алдагдал багатай гэрийн бүрээсийг “Дулааны хэмнэлттэй хувийн орон сууцыг зах зээлд нэвтрүүлэх төсөл”-өөс олгуулав.

Улсын төсвийн 950 сая төгрөгөөр 2006 онд цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбох гэр хорооллын байршил, хүчин чадлыг тодорхойлох ажлыг гүйцэтгэж байна.

Ногоон нуур орчмын болон Хүүхдийн урлан бүтээх төвийн арын гэр хороололд орон сууц барихаар боллоо.

► Нийслэлийн хувьд энэ орчмын гэр хороололд агаарын бохирдолт хамгийн их хувь нэмэр оруулдаг байна. Хот төлөвлөлтийн бодлоготой уялдсан ажлыг авч хэрэгжүүлэхээр БХБЯ, Хотын захирагчийн хамтарсан ажлын хэсгийг байгуулав.

АХБ-тай “Хот байгуулалт, орон сууц”-ны төслийн асуудлаар Санамж бичигт гарын үсэг зурлаа.

Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг “Барилгад чанараар өрсөлдье” Нийтийн аж ахуйн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг “Ундны усны чанар, хүртээмжийг сайжруулах нь” сэдвээр зохион байгууллаа. Энэ ажлын хүрээнд “Барилга-2006” үзэсгэлэнг зохион байгуулав.

Зам тээвэр. Монгол Улсын болон Улаанбаатар хотын зам тээвэр, аялал жуулчлал, шуудангийн үйлчилгээг харилцан уялдаа, зохицуулалттайгаар хөгжүүлэх, үйлчилгээний соёл чанарыг сайжруулах талаар ажиллах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, төлөвлөгөө гаргалаа.

2006 онд 22.511 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж дараах зам, гүүрийн барилга байгууламж, төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Монгол Улсын “Автотээврийн тухай” хуулийн 8.2 дахь заалтын дагуу Монгол-Хятадын хилийн Гашуун сухайт-Ганц модны боомтоос Тавантолгойн нүүрсний уурхай хүртэлх 257 км, Шивээ хүрэн-Сэхээгийн боомтоос Нарийн сухайтын нүүрсний уурхай хүртэлх 58,8 км, Баянхошуу-Өвдөгийн боомтоос Монгол Улсын Тамсагийн газрын тосны орд хүртэлх 225 км авто замын маршрутыг тогтоон баталлаа.

“Автозамын дагуух үйлчилгээний байгууламжийн стандарт”-ыг батлуулан мөрдүүлэв.

“Тээвэр сэргээх төсөл”-ийн хүрээнд нийлүүлэгдсэн автобус, троллейбус, тэдгээрийн сэлбэгийн үнэ болох 9.5 сая долларын өрийг төсвийн хөрөнгө оруулалтад тооцох, нийтийн зорчигч тээврийн төрийн өмчит компаниудын нийгмийн даатгалын шимтгэлд төлөх 200.0 сая төгрөгийг улсын төсвийн хуваарилагдаагүй зардлаас олгох, Япон Улсын буцалтгүй тусламжаар нийлүүлэгдсэн автобусуудыг сэргээн засварлахад зориулан хөрөнгө оруулалт хийх, том оврын автобусыг импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх асуудлуудыг шийдвэрлэв.

Герман Улсын сэргээн босголт, хөгжлийн банкны зээл, тусламжаар хэрэгжих “Бүс нутгийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд авто замын салбарт авах зээлийн гэрээг УИХ-аар соёрхон батлуулав.

Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ыг батлан мөрдүүлэв.

Япон Улсын буцалтгүй тусламжийн хүрээнд баригдах Багануур-Хэрлэнгийн гүүр чиглэлийн авто замын барих гэрээнд гарын үсэг зурлаа.

Өвлийн улиралд улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж буй нийтийн тээврийн хэрэгслийг саадгүй зорчуулах, зам давааг хөдөлгөөний бэлэн байдалд байлгах зорилгоор нийт 39 цэгт байгуулсан шуурхай ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллав.

Хархорин-Цэцэрлэгийн чиглэлийн хэсэгчилсэн 46 км замын барилгын ажлын хугацааг 2 жил болгох, зээлийн хуваарилагдаагүй хөрөнгөөр дээрх чиглэлийн замын эхний 40 км замыг хатуу хучилттай болгоход тавигдах нөхцөл, шаардлагыг багасгах талаар Дэлхийн банкны бүс нутгийн менежертэй зөвшилцөн, санамж бичиг гаргалаа.

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний тоног төхөөрөмж, технологийн шинэчлэлтийг хийж Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрөх олон улсын нислэгийн тоог 50000 хүргэж, орлогыг 8.5-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх зорилтын хүрээнд БНХАУ-ын Бээжингийн чиглэлд гүйцэтгэх нислэгийн давтамж 6 байсныг 8 болгон нэмэгдүүлж, үндэсний агаарын тээвэрлэгчид Бээжин, Хөх хот руу тогтмол нислэг үйлддэг эрхтэй байсныг Шанхай, Урумчи, Тянжин, Хайлаар, Харбинд тогтмол нислэг үйлдэж болохоор эдгээр цэгүүдийг нэмж Хятадын талтай тохиролцов.

“Транс-Өлгий” компанийн Баян-Өлгий-УБ-ын чиглэлд нислэг гүйцэтгэх хүсэлтийг судлан үзэж, “Аэромонголиа” ХХК-ийн тарифаас багагүй тарифаар, мөн тус компанийн нислэгтэй давхцахгүйгээр нислэг гүйцэтгэх зөвшөөрөл өгсөн бөгөөд тус компани нислэг гүйцэтгэж эхлээд байна. Нислэгийн давтамж долоо хоногт хоёроор нэмэгдсэн нь зорчигч урсгал 10 гаруй хувиар нэмэгдэж, сарын дунджаас 230 гаруй зорчигчоор нэмэгдэх хандлагатай байна.

“Марк, үнэт цаас үйлдвэрлэх, борлуулах журам”-ыг батлуулав. Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулсан “Чингис хааны үеийн зоос” нэртэй маркийг хэвлүүлэн гүйлгээнд гаргалаа.

Монгол Улсын Шуудангийн үйлчилгээг хөгжүүлэх Мастер төлөвлөгөөнд тусгагдсан уламжлалт үйлчилгээний төслүүдийг нэгтгэн тодотгож, “Шуудангийн хүргэлтийг оновчтой зохион байгуулах төсөл” боловсруулав.

► *Төсөл хэрэгжүүлснээр шуудан хүргэлтийн давтамж нэмэгдэж, шуудангийн хүргэлтийг шуурхай, найдвартай болгох боломж бүрдэнэ.*

Аялал жуулчлал. “Шинэ оны анхны нар харах аялал” зохион байгууллаа. Арга хэмжээнд 500 гаруй жуулчид оролцсоноос 120 нь гадаадын жуулчид байв.

Өвлийн болон дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Адал явдалт спорт аяллын холбоотой хамтран “Цэвэр цас-цэнгэг агаар” сэдэвт насанд хүрэгчдийн өвлийн спорт аяллыг Богдхан уул, Хэнтийн нуруу-Хагийн хар нуур чиглэл; Хөвсгөл нуурын эрэг дээр “Мөсний баяр” арга хэмжээ зохиогдлоо. Энэхүү арга хэмжээнд гадаадын 30 гаруй жуулчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд, дотоодын 800 орчим жуулчид оролцов.

Монгол үндэсний тоглоом наадгайг дэлхий дахинд сурталчлах, таниулах зорилгоор Монгол-наадгай шагайн наадам арга хэмжээг Оюун ухааны олон улсын музейд зохион байгууллаа.

“Говийн өглөө-Тэмээний баяр”, мөн “Сарлагийн баяр” арга хэмжээг зохион байгууллаа. Энэ арга хэмжээнд 100 гаруй тамирчид оролцсон бөгөөд сүү, цагаан идээний үзэсгэлэн, гар урлалын зүйлсийн худалдаа болж, “Сарлагийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох нь” зөвлөгөөн зохион байгууллаа.

“Нью Жуулчин Турс” ХХК-д УБ - Улаан-Үүд – УБ чиглэлд улс хоорондын зорчигч тээврийн байнгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэрлэж, зорчигч тээвэрлэлтийн байнгын үйлчилгээг нээлээ.

Берлин хотноо болсон “ITB-2006” аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнд 180 орны 10400 байгууллага оролцож, 7000 гаруй сэтгүүлчид сурвалжиллаа. Манай улсын аялал жуулчлалын компаниуд 143 кв.м талбай авч оролцлоо.

Эрчим хүч. “Төвийн бүсийн цахилгаан дамжуулалтын сүлжээг шинэчлэн засварлах төсөл”-д Шведийн Засгийн газраас олгох зээлийн хэлэлцээрийг УИХ- аар соёрхон батлууллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9 сум суурин газарт шинээр баригдах Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөөний зураг, төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг зарлах, үнэлгээний хороо байгуулан үнэлэх арга хэмжээг авлаа.

Монголын хөгжлийн судлалыг дэмжих төв, Японы Сасакава Энхтайвны сантай хамтран зохион байгуулсан “Зүүн хойд Ази дахь Монгол улсын үүрэг оролцоо, түүнийг бэхжүүлэх нь” сэдэвт Олон улсын бага хурал болов.

► *Бага хурлаас “Зүүн хойд Азид Монгол улсын үүрэг оролцоог нэмэгдүүлэх бодлогын зөвлөмж”-ийг гаргаж, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барьсан.*

► *Зөвлөмжид Монголд бие даасан, найдвартай эрчим хүчний системийг хөгжүүлэх зорилгоор Зүүн хойд болон Төв Азийн бүсийн эрчим хүчний хамтын ажиллагаанд, ялангуяа сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах талаар идэвхтэй оролцох, Монголын говийн болон зүүн бүсийн аймгуудын нүүрсний орд газруудад эрэл хайгуул, судалгааны ажил хийх зэрэг бодлогын чанартай хэд хэдэн чухал зөвлөмж тусгагдсан юм.*

Хөдөө аж ахуй. Манай улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хооронд "Малын индексжүүлсэн даатгал төсөл"-ийн хөгжлийн зээлийн гэрээ байгуулагдаж, төсөл өнгөрсөн оноос хэрэгжиж эхэлсэн.

▶ 2009 он хүртэл үргэжлэх туршилтын хугацаанд Увс, Баянхонгор, Хэнтий аймаг хамрагдаад байгаа юм.

▶ Энэ даатгалаар индекст суурилсан буюу тодорхой нутаг дэвсгэрийн статистик үзүүлэлтэд үндэслэн даатгалын хохирол, нөхөн төлбөрийн хувь хэмжээг тооцоолох аргыг бэлчээрийн мал аж ахуйд туршин нэвтрүүлэхээр зорьж байгаа юм.

▶ Төслийн үр дүнгээр малчдын амьжиргаа дээшилж, даатгалын компаниудад зах зээлийн зарчмаар хөгжих боломж нээгдэж байгаа нь байгалийн гамшгийн үед Засгийн газарт ноогдох ачааг хөнгөвчлөх юм.

Япон Улсын буцалтгүй тусламжаар хэрэгжих "Санхүүгийн чадвар муутай ядуу фермерүүдэд дэмжлэг үзүүлэх КР-2" төслийн НОТ бичигт гарын үсэг зурж, энэ оноос эхлэн хэрэгжихээр болов.

"ХХАА-н салбарын удирдах ажилтны зөвлөгөөн", төрөлжсөн семинарыг амжилттай зохион байгуулав.

▶ Зөвлөгөөнд оролцогсад саалийн болон гахайн фермийн аж ахуйн үйл ажиллагаатай танилцав.

КОЙКА-гийн "УМЭАЦТЛ-ийн шинжилгээ хийх хүчин чадлыг дээшлүүлэх төсөл"-ийн шугамаар нийлүүлэгдэж буй оношлогооны тоног төхөөрөмж хүлээн авлаа.

"НӨАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг УИХ-д өргөн барилаа.

▶ Махыг нэмэгдсэн өртөгийн албан татвараас чөлөөлөх нь хавар махны үнэ хөөрөгдөхөөс сэргийлэх нэг арга хэмжээ болох бөгөөд махны үнэ огцом өссөн гол шалтгааны дотор махны үйлдвэрүүд нэмэгдсэн өртөгийн албан татвараас зайлсхийхийн тулд экспортод хямд үнээр мах гаргаж байна гэж үзэн махны үйлдвэрүүдийн боловсруулж дотооддоо борлуулсан махыг НӨАТ-аас чөлөөлснөөр махны үнийн өсөлтийг бууруулах, улмаар түүний хангамж сайжрах нэг боломж бүрдэх юм.

Махны нөөц бүрдүүлсэн аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээний хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулж, аж ахуйн нэгжүүдэд урамшуулал олгохоор шийдвэрлэн, нийт 4 аж ахуйн нэгжид 81.4 сая төгрөг олгуулав.

БНХАУ-аас Монгол Улсын хилийн боомтоор мөн ОХУ-аас Монгол Улсын Эрээн цавын хилийн боомтоор салаа туруутан амьтан болон тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн оруулахыг түр хугацаагаар хорив.

"Экологийн цэвэр бүтээгдэхүүн" хөтөлбөрийг батлуулав.

Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготны хаврын улирлын тодотгох судалгааг Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгээр хийлгүүлэхээр гэрээ байгуулж, шаардагдах зардлын төсвийг хянав.

▶ Одоогийн байдлаар тус хүрээлэнгийн холбогдох ажилтнууд Завхан аймгийн 14 суманд оготны тархалтын судалгааг хийж дуусгаад, Говь-Алтай аймгийн 9, Баянхонгор аймгийн 12 суманд судалгааны ажил хийгдэж байна.

Шүлхий өвчнөөс сэргийлэх, вакцины хүчдэл тогтоох, цусны ийлдсийн дээжийг авах талаар албан даалгавар гаргалаа. Шүлхий өвчнөөс сэргийлэх тарилгад хамрагдсан малд вакцины дархлаа, түүний хүчдэл тодорхойлох зорилгоор дээж авах аргачлал, түүнийг хэрэгжүүлэх албан даалгаврын хамт Улаанбаатар, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудад хүргүүлэв.

Манай улсын ихэнх нутагт цаг агаарын нөхцөл харьцангуй таатай, хэвийн хэмжээний хур тундастай, хэт хүйтэн биш байсан учраас мал өвөлжилтөд онцын хүндрэл гарсангүй, малын зүй бус хорогдол I улирлын байдлаар өнгөрсөн оны мөн үеийнхээс олон дахин бага байна. Орон даяар төл бойжуулах ажил ид явагдаж зарим аймагт бог малын төллөлт дуусах тийшээ хандаж байна. Хаврын тариалалтын бэлтгэл ид хийгдэж байна.

Харилцаа, холбоо. Олон улс руу холбогдох интернэтийн нэгсэн гарцыг бий болгож, зурвасыг өргөтгөх замаар холболтын үнэ тарифыг бууруулж, интернэтийн хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай байгуулсан гэрээ, санамж бичгийн дагуу хамтран ажиллаж байна. Интернэтийн олон улсын хурдны үнийг **392** ам.доллар болгов.

“Дашинчилэн-Булганы шилэн кабелийн дамжуулах сүлжээ байгуулах” төсөл хэрэгжүүлсэнтэй холбогдуулан МЦХ ХК-ий дамжуулах байгууламжийн сүлжээний төв дээрээс тоон радио релейний NMS сигналыг Дашинчилэнд суурилуулсан ZTE компаний S380 төхөөрөмжөөр хянаж, удирдах ажлыг дуусган удирдлагын хянах байгууламжуудыг ашиглалтад хүлээлгэн өглөө.

Төрийн байгууллагуудыг вэб хуудас, ажилтан бүрийг цахим шуудангийн хаягтай болгох төслийн хүрээнд төрийн байгууллагуудын вэб боловсруулах, байршуулахад шаардлагатай 3 сервер компьютерийг нийлүүлж суурилуулах, төрийн байгууллагуудад суурилуулах агуулгын удирдлагын систем, худалдан авалтыг зуучлахпортал сайтыг серверт байршуулах ажлуудыг хийгээд байна.

“Infosec Mongolia-2006” олон улсын хурал, “Монгол програм хангамж-2006” үзэсгэлэн худалдаа, “МХХТ-85” үзэсгэлэн худалдааг тус тус зохион байгууллаа.

“Цахим засаглал” мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх, санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор БНСУ-ын RENOBOT групптэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, хэрэгжүүлж эхлээд байна.

Интернэтийн урсгалыг дамжуулах үнэ тарифыг хямдруулсан арга хэмжээг хэрэгжүүлэх Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч нарын холбоотой хамтран зохион байгуулж, хуваарилалтыг зохицуулан хийгээд байна.

Украин Улсаас худалдан авч хөдөөгийн холбоонд ашиглаж буй тоон радио релейны шугам үйлдвэрлэгч компанитай хамтран ажиллах чиглэлээр Санамж бичиг байгууллаа.

5. БАТЛАН ХАМГААЛАХ, ГАМШГААС ХАМГААЛАХ БОДЛОГО

Манай улсад хадгалагдаж байгаа газрын минийн асуудлыг үе шаттай ил болгохоор “Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалыг батлуулав.

“Дайчилгааны тухай хуулийн хэрэгжилтийг ханган Баруун 5 аймгийн сумдын Засаг дарга нартай Цэргийн бэлтгэл сургалтыг Ховд аймагт зохион байгууллаа. Нийслэлийн дүүргүүдийн хороодын Засаг дарга нартай 3 хоногийн цэргийн бэлтгэл сургалтыг явуулав.

2005-2006 оны сургуулийн жилийн Зэвсэгт хүчний сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу удирдах бүрэлдэхүүний стратегийн цугларалтыг “Монгол Улсын аюулгүй байдлын гадаад шинэ орчин ба бэлэн байдал” сэдвээр зохион байгууллаа.

Зэвсэгт хүчний хугацаат цэргийн албан хаагчидтай ангиудын жагсаалын дарга нарын орон тоог “Сургагч ахлагч” болгон өөрчилж, рот /батарей/-ын жагсаалын дарга нарын 21 хоногийн дамжааг БХИС-ийн сургалтын материаллаг баазыг түшиглэн явуулж байна.

Монгол Улсын иргэн сансарт ниссэн, сансрын хамтарсан нислэгийн 25 жилийн ой, Зэвсэгт хүчний 85 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүллээ.

“Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулах ажлын хэсгийн хурлыг зохион байгуулан гарсан дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн цэргийн бодлогын зөвлөхөд танилцуулан саналыг тусгаж дахин боловсруулаад байна.

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жил, Монгол Улсын Зэвсэгт хүчний 85 жилийн ойд зориулан “Монгол цэрэг-800” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав.

► *Бага хурлын зорилго нь Суут богд Чингис хааны байгуулсан Их Монгол Улсын цэргийн дэлхий, бүс нутаг, монголын түүхэнд гүйцэтгэсэн үүргийг уламжлал-шинэчлэлийн хүрээнд, судалгааны ажлын өнөөгийн төвшинд авч үзэхэд оршиж байв.*

Монгол Улсад цэрэг техникийн тусламж үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсын БХЯ, ОХУ-ын “Конструкторское бюро приборостроение” ТӨҮГ хооронд байгуулсан гэрээний дагуу нийлүүлсэн зэвсэг, галт хэрэглэл, Герман Улсаас нийлүүлсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн гаалийн бүрдүүлэлтийг хийж, хүлээн авсан.

Батлан хамгаалах салбарын “Орон сууц” хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүрэгт 29 айлын орон сууцны барилгыг ашиглалтанд оруулж, хэрэгжүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулж, БНХАУ-аас ирүүлсэн тусламжийн барааг зарж борлуулан, орон сууцны барилга барих хөрөнгө төвлөрүүлэх ажил үргэлжлэн хийгдэж байна.

► *“Иракийн эрх чөлөө” олон улсын цэргийн ажиллагаанд оролцож буй цэргийн багийн ҮI ээлжийн бүрэлдэхүүн “Эко” баазад хүрэлцэн очиж үүргээ амжилттай биелүүлж байна..*

► *Косово дахь НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд дэмжлэг үзүүлж буй Олон үндэстний зүүн хойд дивизийн Митровица хотод байрлах Францын батальоны бүрэлдэхүүн дэх Бельгийн Вант Улс, Люксембург Улс, Монгол Улсын хамтарсан “BELUMOKOS-20” ротын бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэсэн манай цэргийн багийнхан үүргээ амжилттай биелүүлээд эх орондоо хүрэлцэн ирлээ.*

► *“Афганистаны үндэсний армийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд үүрэг гүйцэтгэж байгаа Сургалтын хөдөлгөөнт багийн Ү ээлжийн бүрэлдэхүүн Афганистаны үндэсний армийн артиллерийн салбаруудын офицер, ахлагч, цэргүүдийг сургах, артиллерийн зэвсэглэлд засвар үйлчилгээ хийх үүргээ амжилттай хэрэгжүүлж байна.*

► *Сиerra Леон Улсад зохион байгуулж байгаа НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй цэргийн багийнхан тус улсын Фрийтаун хот дахь НҮБ-ын Нарлаг баазад байрлан үүрэг гүйцэтгэж байна.*

Гамшгаас хамгаалах. “Шувууны томуу өвчнөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын тогтоол, “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын албан даалгавар гарган, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

2006 он гарсаар Дорнод, Баянхонгор, Сэлэнгэ аймагт малын халдварт боом өвчин 3 удаа, хүнд халдварласан тохиолдол Дорнод, Увс аймагт 2 удаа гарлаа. Боом өвчнөөр хорогдсон малыг булж устган, ариутгал, халдваргүйжүүлэлт хийж, вакцинжуулалтанд 82 хүн, 1479 толгой мал хамрагдаж боом өвчний халдвараас хамгаалагдсан байна. Мал, амьтны халдварт галзуу өвчин Завхан, Баян-Өлгий, Говь-Алтай, Хөвсгөл, Ховд аймгийн 7 суманд 13 удаа гарч, галзуу өвчнөөр өвчилсөн 33 мал, 27 чоно, үнэг, тэжээвэр нохойг устган булж, ариутгал, халдваргүйжүүлэлт хийсэн ба вакцинжуулалтанд 162 хүн, 5509 толгой мал хамрагдаж, галзуу өвчний халдвараас хамгаалагдсан байна.

2006 он гарсаар 7 аймгийн 9 сум, нийслэлийн 2 дүүрэгт 11 удаа ой, хээрийн түймэр гараад байна. Ой, хээрийн түймрийг унтраах ажилд Онцгой байдлын төв орон нутгийн байгууллагаас 2005 онд 1194 албан хаагч, 4159 хүн, 2 нисдэг тэрэг, 384 автомашин, техник, 2006 онд 54 албан хаагч, 400 хүн, 39 автомашин, техник оролцжээ.

6. ГАДААД БОДЛОГО

2006 онд Монгол Улсын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хоёр талын шугамаар болон олон талын үндсэн дээр өргөжүүлэн хөгжүүлэх талаар урьдаас төлөвлөгдсөн арга хэмжээнүүдийн зэрэгцээ Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэхтэй холбогдсон нэлээд ажлыг гүйцэтгэж байна.

Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл болох хөрш орнууд-ОХУ, БНХАУ-тай тэнцвэртэй, эрх тэгш харилцан ашигтай байх зарчимд тулгуурласан өргөн цар хүрээтэй хамтын ажиллагаа амжилттай хөгжиж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ОХУ-д хийх айлчлалын бэлтгэл ажлын хүрээнд саяхан ОХУ-ын Гадаад хэргийн сайдыг хүлээн авч айлчлууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс БНХАУ-д 2005 онд хийсэн төрийн айлчлалын үеэр хийсэн тохиролцоонуудыг хэрэгжүүлэхэд анхааран ажиллаж байна. Мөн 2006 онд Монгол Улсын Ерөнхий сайдыг БНХАУ-д айлчлуулахаар Хятадын талтай зарчмын хувьд тохиролцоод байна.

УИХ-ын дарга БНСУ, Швед, Норвеги, Финлянд, Данийн Вант Улс, Бүгд Найрамдах Финланд Улс, Норвегийн Вант Улсад, Ерөнхий сайд Япон, айлчилж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх асуудлаар тодорхой тохиролцоонуудад хүрсэн. Монгол Улсын Ерөнхий сайд Япон Улсад хийсэн айлчлалын үеэр 2 шаттай иөнийн зээлийн хэлэлцээр байгуулсан нь Япон Улстай иж бүрэн тншлэлийн харилцааг баяжуулж, харилцан ашигтай байх чиглэлд хийсэн чухал алхам болов.

Монгол, Хятадын хилийг хоёр дахь удаагаа хамтран шалгасан тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын протокол, хоёр улсын хилийн зурвас газрын зургийг УИХ-аар соёрхон батлууллаа.

ИБУИНВУ-ын Лондон хотын захирагч Д.Брювер, ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.Лавров, АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга асан Ж.Бейкер нар Монгол Улсад тус тус айлчлахдаа Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нарт бараалхлаа.

Солонгосын Шинхан банк Солонгост байгаа монгол иргэдийн мөнгийг Монгол руу албан ёсоор гуйвуулж байхаар болов. 2000 хүртэл ам.доллар гуйвуулахад банкны шимтгэл 18000 вон байдаг бол “Шинхан” банк манай иргэдэд хөнгөлөлт үзүүлж 9000 воноор үйлчлэх, шилжүүлгийн мэдүүлгийн монгол хэл дээрх загварыг бүх салбарууддаа тавихаар боллоо.

Ирэх 5 жилд НҮБ-аас манай оронд үзүүлэх хөгжлийн тусламжийн ерөнхий хүрээг тодорхойлсон үндсэн баримт бичигт УИХ-ын гишүүн, Гадаад хэргийн сайд Н.Энхболд, НҮБ-ын Суурин зохицуулагч хатагтай Пратиба Мета нар гарын үсэг зурав.

ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ

Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Сэлэнгэ мөрөн, Онон, Балж голын урсацад тохируулга хийх санал боловсруулах тухай”, УИХ-ын шинэчилсэн найруулгын төсөл, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай, Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хууль, Хүн амын орлогын албан татварын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, нөхөн олговор олгох тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиудад өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төсөл, “Монгол Улсын шүүгчийн зэрэг дэвийн журам батлах тухай”, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн алба хашиж байсан П.Очирбатын зарим хангамжийн тухай” зэрэг УИХ-ын тогтоолын төсөлд өгөх Засгийн газрын санал дүгнэлтийн төсөл, “Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр зөвшөөрөх, зохион байгуулалтын бүтэц батлах тухай”, “Хил хамгаалах байгууллагын цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийн норм батлах тухай”, “Орон сууц шилжүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.

Гэрээ соёрхон батлах тухай, Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам батлах тухай”, “Дархлаажуулалтын үндэсний товлолыг шинэчлэн батлах тухай”, “2006 онд хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалт батлах тухай”, “Техник, багаж хэрэгслээр хангах тухай” зэрэг Засгийн газрын 34 тогтоолын төсөл, “Боловсролын баримт бичиг, эрдмийн зэрэг, эрдмийн цолыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай” Монгол Улс ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр батлах тухай, “Монгол Росцветмет нэгдлийн эрх зүйн байдлын тухай” зэрэг Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, “Гарын үсэг зурах бүрэн эрх олгох тухай” Ерөнхий сайдын захирамжийн төсөлд тус тус санал өглөө.

Манай Улсад хууль бусаар оршин суугаа гадаадын иргэд /харьяалалгүй хүн/-ийн бүртгэл, хяналт болон гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт болон төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаанд шалгалт хийж, холбогдох арга хэмжээг авч байна.

БНУУ-ын Хууль зүйн сайдын урилгаар Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд тэргүүтэй төлөөлөгчид тус улсад ажлын айлчлал хийж байна.

Айлчлалын үеэр Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр БНУУ-ын Хууль зүйн сайд, Ерөнхий прокурорын орлогч, Шүүхийн зөвлөлийн дарга, Их Хурлын орлогч дарга, Дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Үндсэн хуулийн цэцийн дарга нартай уулзах бөгөөд Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам БНУнгарУ-ын Хууль зүйн яам хоорондын хамтын ажиллагааны протоколд гарын үсэг зурах юм.

Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр “Хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох” чиглэлээр төсөл хэрэгжүүлэх болсонтой холбогдуулан Европын сэргээн босголт хөгжлийн банкны төлөөлөгчид манай улсад ажлын айлчлал хийлээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

----- о О о -----